

**ДЭЛХИЙН ЦАГ УУРЫН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН
СИСТЕМИЙН КОМИССЫН АРВАН ЗУРГАДУГААР ХУРАЛДААНД
ОРОЛЦСОН ТУХАЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2016.12.01

Дэлхийн Цаг Уурын Байгууллагын Үндсэн системийн комиссын арван зургадугаар хуралдаан 2016 оны 11 дүгээр сарын 23-наас 29-нд БНХАУ-ын Гуанжу хотноо болж уг хуралд ЦУОШГ-ын дарга С.Энхтүвшин, НЦУТ-ийн төвийн Захиргаа, дотоод хяналт, чанарын хэлтсийн төсөл, хөтөлбөр, гадаад харилцааны ахлах мэргэжилтэн Б.Эрдэнэмөнх нар оролцов. Тус хуралд ДЦУБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Петтери Таалас болон 68 орны цаг байгууллагын төлөөлөгчид, экспертүүд мөн бусад олон улсын байгууллагуудын ажиглагчид зэрэг нийт 200 гаруй төлөөлөгчид оролцлоо.

Хурлаар ДЦУБ-ын Үндсэн системийн комиссын Ерөнхийлөгч Фредрик Брэнски өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд хийсэн ажлын тайлангаа хэлэлцүүлж мөн комиссын ажлын албаны бүтэц, холбогдох удирдамж, гарын авлага болон заавар журам зэргийг хэлэлцэж батлав.

Тус хурлаар ДЦУБ-ын Үндсэн системийн комиссын Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийн сонгууль явагдаж дараагийн дөрвөн жилд тус комиссийг удирдан ажиллах Ерөнхийлөгчөөр Канад улсын Цаг уурын албаны Байгаль орчин болон цаг уурын урьдчилан мэдээлэх төвийн Ерөнхий захирал ноён Майкал Жин, Дэд Ерөнхийлөгчөөр БНХАУ-ын Цаг уурын газрын Дэд дарга хатагтай Меиян Жиао нар тус тус сонгогдлоо.

Уг хурлын үеэр ЦУОШГ-ын дарга С.Энхтүвшин ДЦУБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Петтери Тааластай уулзаж цаашдын хамтын ажиллагааны талаар ярилцаж мэдээлэл солилцох системийг шинэчлэх талаар хүсэлт тавилаа. Мөн БНХАУ-ын Цаг уурын газрын дарга ноён Гуогуан Зентэй уулзаж цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

Тайлан бичсэн:

Нислэгийн цаг уурын төвийн Захиргаа,
дотоод хяналт, чанарын хэлтсийн Төсөл,
хөтөлбөр, гадаад харилцааны ахлах мэргэжилтэн

Б.Эрдэнэмөнх